



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ХҮН АМЫН ӨСӨЛТ, ӨӨРЧЛӨЛТ, ХАНДЛАГА

Б.Уранбилэг

*Үндэсний тооцоо, шинжилгээ
судалгааны газар*



Улаанбаатар

2017 он

1. Хүн амын өсөлт

Монгол Улсын хүн амын өсөлт 20-р зууны эхэнд маш бага, нэг орчим хувь байсан бол 20-р зууны сүүл 1956-1989 онд эрчимтэй өсөж, 3 хувьд хүрч байжээ.


Хорьдугаар зууны эхэн үед манай улсын хөгжил буурай, хүн амын дунд халдварт өвчний тархалт өндөр, эрүүл мэндийн түвшин доогуур, мөн тухайн үеийн нийгмийн бүх давхаргыг хамруулсан хэлмэгдүүлэлт, Халх голын дайн зэргээс шалтгаалан хүн амын өсөлт маш бага байв.

Харин 1956-1989 оны хооронд улс даяар үйлдвэрлэл, бүтээн байгуулалтын эрчимтэй үе эхэлж, хүн ам, нийгмийн хамгаалал, тэр дундаа эрүүлийг хамгаалах салбар хурдацтай хөгжиж, нийтийг хамарсан өвчнийг илрүүлэн эмчлэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлийн томоохон арга хэмжээг авсан нь хүн амын эрүүл мэндийг сайжруулан, нас баралтын түвшин буурахад голлон нөлөөлсөн байна. Түүнчлэн олон хүүхэдтэй эхчүүдэд тэтгэвэр, тэтгэмж олгох зэргээр төрөлтийг дэмжих шат дараатай арга хэмжээ авч байсан нь хүн амын өсөлтийг дэмжих бодлогод эергээр нөлөөлжээ. Чухам энэ үед Монгол Улсын хүн амын өсөлт хамгийн оргил үедээ хүрч, цаашид инерцээрээ өсөхөд суурь түвшинг харьцангуй нэмэгдүүлж, өнөөгийн хүн ам зүйн цонх үе үүсэх гол нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Манай улсын улс төр, эдийн засгийн тогтолцоонд өөрчлөлт орсон 1990-ээд оноос хойш хүн амын өсөлт эрчимтэй саармагжиж, тухайлбал, хүн амын 2000 оны тооллогоор жилийн дундаж өсөлт хамгийн бага буюу 1.4 хувь болсон байв.

Зураг 1. Хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь, 2000-2016 он

*- Урьдчилсан гүйцэтгэл



Энэ үед хүн амын өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл нь төрөлтийн түвшин, өөрөөр хэлбэл, төрөх насны нэг эмэгтэйн амьдралын хугацаанд төрүүлэх хүүхдийн тоо хамгийн бага буюу 1-2 болж буурсан нь нөлөөлсөн байна.


Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь 2007-2009 он хүртэл аажим өсөж 1.9 хувь байсан бол, 2010 онд эргэн саарч 1.6 хувь байснаа, 2011-2014 оны хооронд тогтвортой өссөөр 2.2 хувьд хүрчээ. Харин 2015 оноос аажмаар буурч, 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.9 хувь боллоо.

2. Нас хүйсийн бүтэц

Монгол Улсын хүн ам 1969 оны тооллогоор залуу насны бүтэцтэй буюу 0-14 насны хүн амын эзлэх хувь хамгийн өндөр (44.4%) байсан бол тооллого ахих тутам 15-64 насны хүн амын эзлэх хувь аажмаар өсөж, 20 идэр насны бүтэцтэй болсон байна.

Мөн 2000 онд 50, түүнээс дээш насныхны нийт хүн амд эзлэх хувь 10.1 байснаа, 2016 онд 15.1 хувь болж, 5 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 2. Монгол Улсын хүн амын насны бүтэц, дүнд эзлэх хувиар, 1963-2016 он



Нийт хүн амд хөдөлмөрийн насныхны эзлэх хувь өндөр байх үеийг хүн ам зүйн цонх үе гэж нэрлэдэг. Энэ үед мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх урт хугацааны бодлого хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэн, хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлсэн нөхцөлд эдийн засгийн хөгжилд эерэгээр нөлөөлдөг учраас эдийн засгийн утгаараа их ач холбогдолтой үе гэж үздэг.

Хүн ам зүйн цонх үеийг илэрхийлэх үзүүлэлтүүдийн нэг нь хүн ам зүйн ачаалал буюу хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн тоо гэсэн үзүүлэлт юм.

Хүн ам зүйн ачаалал 1969 онд 102 байгаа нь хөдөлмөрийн нас(15-64)-ны 1 хүнд хөдөлмөрийн бус нас(0-15 нас хүртэлх хүүхдүүд болон 65, түүнээс дээш насны ахмадууд)-ны 1 хүн ногдож байсан бол үүнээс хойш тасралтгүй буурч 2000 онд 45-д хүрч, 2016 онд 51 буюу хөдөлмөрийн насны 2 хүн тутамд хөдөлмөрийн бус насны 1 хүн ногдож байгааг харууллаа.

Хүснэгт 1. Хүн ам зүйн үзүүлэлтүүд, 1963-2016 он

Үзүүлэлтүүд	1963	1969	1979	1989	2000	2010	2015	2016
Хүн ам зүйн ачаалал: нийт	82.8	101.7	97.1	84.9	64.6	45.0	49.9	50.8
хүүхэд	71.3	89.6	87.3	77.4	58.9	39.6	44.2	45.0
хөгшид	11.5	12.1	9.8	7.5	5.7	5.4	5.6	5.8
Хөгшрөлтийн индекс								
65+	16.1	13.5	11.2	9.7	9.7	13.6	12.8	13.0
Голч нас	22.8	18.7	17.5	18.8	21.6	25.8	26.9	27.1

Хөгшрөлтийн индекс буюу (0-15 насны 100 хүүхэдэд ногдох 65, түүнээс дээш настай хүний тоо) хөгшид, хүүхдийн харьцааг харвал 1963-1989 онд төрөлтийн түвшин өндөр, хүүхдийн эзлэх

хувь их байснаас шалтгаалан 100 хүүхдэд ногдох хөгшдийн тоо 16-аас 10 болон буурсан байна.


Харин 1989-2000 онд төрөлтийн түвшин буурч, харин нөгөө талаасаа хөгшдийн хүн амд эзлэх хувь нэмэгдсэнтэй уялдан энэ үзүүлэлт хэвээр байснаа 2010 оноос хойш нэмэгдэж 100 хүүхдэд ойролцоогоор 13-14 хөгшид ногдох болсон байна. Энэ нь 2010 оноос хойш төрөлтийн түвшин нэмэгдсэнтэй холбоотой юм.

Хүн амын тоог таллан буюу 50 хувиар зааглаж байгаа насыг “голч нас” гэх ба 1963 онд голч нас ойролцоогоор 23 байгаа нь нийт хүн амын 50 хувь нь 23-аас доош настай, үлдсэн нь үүнээс дээш настай байсныг харуулж байна. Энэ үзүүлэлт 1963-1979 оны тооллого хооронд 4 жилээр багсаж 18 байснаа 1979-2016 онд тасралтгүй нэмэгдэн, 9 жилээр хойшилж, 27 болжээ. Өөрөөр хэлбэл, 2016 онд хүн амын тал хувь нь 27-оос доош, үлдсэн нь үүнээс дээш настай байна.

3. Дундаж наслалтын өөрчлөлт, хандлага

Шинээр төрсөн хүүхдийн эрүүл мэнд, амьдрах нөхцөл нь цаашид хэвээр хадгалагдана гэж үзвэл түүний үргэлжлэн амьдрах жилээр тооцсон дундаж хугацааг “дундаж наслалт” гэдэг.

Зураг 3. Төрөлтөөс тооцсон хүн амын дундаж наслалт, жилээр, 2006-2016 он




Төрөлтөөс тооцсон хүн амын дундаж наслалт 2006 онд эрэгтэйчүүдэд 62.6 жил, эмэгтэйчүүдэд 69.4 жил байснаа 2015 он хүртэл аажмаар нэмэгдэж, эрэгтэйчүүд 66.0, эмэгтэйчүүд 75.8 жил болсон байна. Харин 2016 онд эрэгтэйчүүд 75.1 болж 2015 оноос 0.7 жилээр, эмэгтэйчүүд 65.6 болж 0.4 жилээр тус тус буурчээ.

Энэ нь нялхсын эндэгдлийн түвшнээс шууд хамааралтай бөгөөд 2016 онд 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 16.8 болж, өмнөх оноос 1.8 пунктээр нэмэгдсэн нь цаашид үргэлжлэн амьдрах магадлалыг багасган, төрөлтөөс тооцсон дундаж наслалт буурахад нөлөөлжээ.

Хүн амын дундаж наслалтын тооцоонд “дундаж наслалтын хүснэгт”-ийг байгуулдаг бөгөөд уг хүснэгтээр насны бүлэг бүрийн үргэлжлэн амьдрах хугацааг тодорхойлдог.

Насны бүлгээрх нас баралтын түвшин буурах нь тухай насны бүлгийн хүн амын цаашид үргэлжлэн амьдрах магадлалыг ихэсгэн, амьдрах хугацааг нэмэгдүүлэх зүй тогтолтой.



Дундаж наслалтын тооцооллын хүснэгтээс гарсан нас баралтын түвшинг насны бүлгээр авч үзвэл /хүснэгт 2/, улсын түвшинд 2006-2016 онд 5-9 насны хувьд өөрчлөлтгүй, 10-19 насны хүн амын нас баралтын түвшин 0.1 пунктээр нэмэгдэж, 20, түүнээс дээш насны хувьд 0.2-10.3 пунктээр буурчээ. Энэ нь цаашид үргэлжлэн амьдрах магадлалыг ихэсгэн, амьдрах хугацааг тогтвортойгоор нэмэгдүүлсэн байна. Тухайлбал, 2006-2016 онд ахмад буюу 55-59 насныхны нас баралтын түвшин 3 пунктээр буурч, үргэлжлэн амьдрах хугацаа 2006 онд 23.6 жил байснаа 2016 онд 26.3 болж, 2.7 жилээр нэмэгдсэн бол 70, түүнээс дээш насныхны нас баралтын түвшин 10.3 пунктээр буурч, цаашид үргэлжлэн амьдрах хугацаа 2006 онд 11.4 жил байснаа 2016 онд 13.9 болж, 2.5 жилээр хойшилжээ.

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн насны бүлгээрх нас баралтын түвшинг 2006 онтой харьцуулбал 2016 онд 5-19 насныханд маш багаар нэмэгдсэн /0.0-0.2 пунктээр/ бол бусад насны бүлэгт /0.2-10.1 пунктээр/ буурсан хандлагатай байна /зураг 4/.


Тухайлбал, 40, түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн хувьд 5 насны бүлгээр тооцсон нас баралтын түвшин 2016 онд 2006 оноос 0.1-9.8 пунктээр буурч, цаашид үргэлжлэн амьдрах

хугацаа 0.7-1.2 жилээр нэмэгдсэн бол уг насны эмэгтэйчүүдийн хувьд 1.6-10.1 пунктээр буурч, үргэлжлэн амьдрах хугацаа 1.9-3.7 жилээр тус тус нэмэгджээ.

Хүснэгт 2. Тодорхой насыг насалсан хүний цаашид амьдрах дундаж хугацаа /жилээр/, насны бүлгээр тооцсон нас баралтын түвшин /1000 хүнд ногдохоор/, улсын дүнгээр, 2006-2016 он

Нас, насны бүлэг	2006		2010		2015		2016		Зөрүү /2016-2006/	
	Амьдрах дундаж хугацаа	Нас баралт	Амьдрах дундаж хугацаа	Нас баралт	Амьдрах дундаж хугацаа	Нас баралт	Амьдрах дундаж хугацаа	Нас баралт	Амьдрах дундаж хугацаа	Нас баралт
0	65.8	23.3	68.1	19.9	69.9	15.5	69.6	19.2	3.7	-4.1
1-4	67.1	1.5	68.6	1.9	70.1	1.0	70.4	1.0	3.3	-0.5
5-9	63.9	0.4	65.1	0.6	66.6	0.4	66.9	0.4	3.0	0.0
10-14	59.0	0.4	60.3	0.5	61.7	0.5	62.0	0.5	3.0	0.1
15-19	54.1	0.7	55.4	0.8	56.9	0.9	57.2	0.9	3.0	0.1
20-24	49.3	1.4	50.6	1.4	52.1	1.2	52.4	1.2	3.1	-0.2
25-29	44.7	2.2	45.9	1.8	47.5	1.4	47.7	1.4	3.0	-0.8
30-34	40.2	3.0	41.4	2.9	42.9	2.1	43.1	1.9	3.0	-1.1
35-39	35.8	4.5	36.9	3.9	38.4	3.2	38.6	3.0	2.9	-1.5
40-44	31.5	7.1	32.6	5.7	34.1	4.8	34.3	4.5	2.8	-2.6
45-49	27.4	9.3	28.6	8.9	30.0	7.2	30.2	6.9	2.7	-2.5
50-54	23.6	14.1	24.7	13.1	26.1	10.2	26.3	10.2	2.7	-3.8
55-59	20.0	18.1	21.2	18.7	22.6	15.7	22.7	15.5	2.7	-2.7
60-64	16.6	25.1	17.9	27.3	19.3	22.2	19.4	19.3	2.8	-5.8
65-69	13.8	38.0	15.1	37.3	16.3	30.0	16.5	33.0	2.7	-5.0
70+	11.4	80.8	12.7	83.6	13.8	73.8	13.9	70.5	2.5	-10.3

Зураг 4. Тодорхой насыг насалсан хүний цаашид амьдрах дундаж хугацаа /жилээр/, насны бүлгээр тооцсон нас баралтын түвшин /1000 хүнд ногдохоор/, хүйсээр, 2006, 2016 он



4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Манай улс даатгуулагч, ажил олгогч шимтгэл төлөх замаар тэтгэврийн хуримтлал бий болгон түүнээс тэтгэвэр авагчдынхаа тэтгэвэр, тэтгэмжийг төвлөрсөн журмаар олгодог хуваарилалтын системтэй билээ. Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу даатгалын 5 төрөл тус бүр нь мөнгөн хөрөнгийн бие даасан сантай байдаг.

Нийгмийн даатгалын сангийн (НДС) орлого, зарлагын хэмжээ 2006-2017 онд тасралтгүй өсөж, 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр орлого 2,1 их наяд төгрөгт хүрч, 2006 оныхоос 8.9 дахин, зарлага 1,9 их наяд төгрөгт хүрч, 2006 оноос 9.5 дахин нэмэгджээ.

НДС-гийн орлогыг бүрдүүлэгч даатгуулагч иргэд 2017 онд 1 сая, тэтгэвэр авагчдын тоо 388.3 мянга болж, 2006 оныхоос даатгуулагч 2.2 дахин, тэтгэвэр авагч 1.3 дахин өссөн байна.

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл, зарим үзүүлэлтээр, 2006-2017 он

Үзүүлэлтүүд	2006	2010	2012	2014	2015	2016	2017*
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая төг	238,566.3	622,718.7	799,217.0	1,140,580.6	1,187,436.3	1,314,634.0	2,118,869.1
Үүнээс:							
Тэтгэврийн даатгалын сангийн	174,112.1	462,795.1	491,924.4	704,409.0	718,716.6	767,532.6	1,447,846.6
Тэтгэмжийн даатгалын сангийн	10,533.3	17,996.2	35,450.1	78,408.3	81,098.1	86,874.2	109,019.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн	7,670.0	91,257.5	166,612.8	231,728.0	248,068.4	302,608.8	370,532.9
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	41,084.0	31,556.6	67,942.8	99,740.8	109,748.0	125,136.2	147,595.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн	5,156.9	19,113.3	37,286.9	26,294.5	29,805.2	32,482.4	43,875.3
Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, хувийн жингээр							
Үүнээс:	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэтгэврийн даатгалын сангийн	73.0	74.3	61.6	61.8	60.5	58.4	68.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	4.4	2.9	4.4	6.9	6.8	6.6	5.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн	3.2	14.7	20.8	20.3	20.9	23.0	17.5
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	17.2	5.1	8.5	8.7	9.2	9.5	7.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	2.2	3.1	4.7	2.3	2.5	2.5	2.1
Нийгмийн даатгалд даатгуулагчид, мян.хүн	480.9	658.0	863.2	1,018.6	989.0	1,028.0	1,040.2
Заавал	448.5	594.3	761.9	832.9	799.8	799.5	843.8
Сайн дураар	32.4	63.7	101.3	185.7	189.2	228.5	196.5
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая төг	199,517.4	531,417.6	943,399.9	1,301,122.3	1,560,370.0	1,786,181.8	1,890,083.5
Үүнээс:							
Олгосон тэтгэврийн хэмжээ, сая төг	158,024.3	375,032.7	734,130.6	1,011,858.0	1,198,946.3	1,330,654.7	1,415,411.3
Өндөр настны	111,790.0	265,643.3	516,542.0	724,779.1	867,747.6	973,767.0	1,066,283.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	20,573.7	59,255.6	111,798.7	156,258.8	184,755.9	200,630.6	182,998.6
Тэжээгчээ алдсаны	15,354.0	27,378.6	47,147.6	54,852.4	59,806.1	63,144.2	60,177.5
Цэргийн	10,306.6	22,755.2	58,642.3	75,967.7	86,636.7	93,112.9	105,951.8
Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая төг	41,493.1	156,384.9	209,269.3	289,264.3	361,423.7	455,527.1	474,672.2
Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувийн жингээр	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Олгосон тэтгэвэр	79.2	70.6	77.8	77.8	76.8	74.5	74.9
Өндөр настны тэтгэвэр	56.0	50.0	54.8	55.7	55.6	54.5	56.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	10.3	11.2	11.9	12.0	11.8	11.2	9.7
Тэжээгчээ алдсаны	7.7	5.2	5.0	4.2	3.8	3.5	3.2
Цэргийн	5.2	4.3	6.2	5.8	5.6	5.2	5.6
Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая төг	20.8	29.4	22.2	22.2	23.2	25.5	25.1
Тэтгэвэр авагчдын тоо, мян.хүн	290.5	337.5	334.6	345.8	387.3	376.9	388.3
Өндөр настны тэтгэвэрт авагчдын	190.1	218.8	224.7	242.5	268.4	269.0	282.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	51.9	70.0	65.8	65.4	77.9	70.1	67.9
Тэжээгчээ алдсаны	35.4	35.1	29.9	23.3	25.6	22.5	21
Цэргийн	13.1	13.6	14.2	14.6	15.4	15.3	17.3
Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын зөрүү	39,048.9	91,301.1	-144,182.9	-160,541.7	-372,933.7	-471,547.8	228,785.6
Тэтгэврийн насны хүн ам**, мян.хүн	196.1	202.7	214.7	243.8	244.2	257.5	-

*Урьдчилсан гүйцэтгэл /НДС-ийн орлогод улсын төсвийн татаас орсон/

** Хөдөлмөрийн хуулийн дагуу 55, түүнээс дээш насны эмэгтэйчүүд, 60, түүнээс дээш насны эрэгтэйчүүдийг хамруулав.


Нийгмийн даатгалын сангийн орлогод 2006-2017 оны дунджаар тэтгэврийн даатгалын сангийн орлого 67.6 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийнх 16.9 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийнх 7.8 хувь, тэтгэмжийн даатгалын сангийнх 4.8 хувь, үлдсэн 2.8 хувь нь ажилгүйдлийн даатгалын сангийн орлоготус тус эзэлж байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлагад 2006-2017 оны дунджаар тэтгэмжид 23 орчим хувь нь, үлдсэн 77 орчим хувь нь тэтгэвэрт, үүнээс 55 хувь нь өндөр настны тэтгэвэрт, 12 хувь нь

хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгогдсон бол тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэвэрт тус бүр 5 орчим хувь нь зарцуулагджээ.

Хэдийгээр НДС-гийн орлого, зарлагын хэмжээ абсолют тооны хувьд тасралтгүй өссөн хэдий ч өсөлтийн хувь хэлбэлзэлтэй байна /Зураг 5/.


Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын жилийн өсөлт, хувиар, 2007-2017 он



*-урьдчилсан гүйцэтгэлээр

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын ихэнх хувийг бүрдүүлэгч өндөр настны тэтгэврийн сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтыг харвал 2006 онд 1 даатгуулагчаас сард дунджаар 30171 төгрөгийг тэтгэврийн санд хуримтлуулж байсан бол 2016 онд 62219 болж, 2 дахин нэмэгдсэн, харин нөгөө талдаа тэтгэврийн сангийн зардал буюу өндөр настны тэтгэвэр авагч нэг хүн 2006 онд сард дунджаар 49005 төгрөгийн тэтгэвэр авч байснаа 2016 онд 301663 болж 6.2 дахин нэмэгдсэн байна.

Зураг 6. Тэтгэврийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, төгрөгөөр



*-урьдчилсан гүйцэтгэлээр

Энэ хугацаанд тэтгэврийн сангийн орлого, зарлагын харьцаа тасралтгүй нэмэгдсэн байна. Тухайлбал, нэг өндөр настанд олгосон тэтгэврийн сарын дундаж хэмжээ 2006 онд даатгуулагчийн төлсөн шимтгэлээс 1.6 дахин өндөр байснаа 2016 онд 4.8 дахин өндөр болж нэмэгдсэн байна. Энэ нь тэтгэврийн сан алдагдалтай төдийгүй тасралтгүй нэмэгдсээр байгааг илтгэж байна.

5. ДҮГНЭЛТ

- Хүн амын насны бүтэц идэршиж, түүнд 50, түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь нэмэгдэж байна.
- Дээрх насны бүлгийн хүн амын нас баралтын түвшин аажмаар буурч, үргэлжлэн амьдрах хугацаа нэмэгдэж байгаа зүй тогтол нь тодорхой хугацааны дараа тэтгэвэрт гарах насны

хүн амын эзлэх хувь тасралтгүй өсөхөд нөлөөлж, тэтгэврийн сангийн ачааллыг нэмэгдүүлэхээр байна. Тухайлбал, 2016 оны байдлаар хүн амын 8.2 хувийг тэтгэврийн насныхан (эмэгтэй 55, эрэгтэй 60, түүнээс дээш нас) эзэлж байгаа бол хүн амын хэтийн тооцоогоор¹ энэ насныхан 5 жил тутамд дунджаар 1.4 хувиар нэмэгдсээр 2045 онд 16.3 хувьд хүрч өнөөгийн түвшнээс 2 дахин нэмэгдэхээр байна.

- Тэтгэвэр авагчдын тоо төдийгүй тэдгээрт олгосон тэтгэврийн хэмжээ өсөж, нийгмийн даатгалын сангийн ачааллыг нэмэгдүүлэн, сүүлийн 6 жилд тэтгэврийн сан алдагдалтай болсон нь цаашид тэтгэврийн санг алдагдалгүй болгоход анхаарах, тэтгэврийн насыг сангийн орлого бүрдүүлэлт болон зарлагын харьцаанаас хамааруулан оновчтой тогтоох, урт хугацаанд харилцан уялдаатай, тогтвортой бодлогоор хангах шаардлагатайг харуулж байна.
- Тэтгэвэрт гарсан ахмадуудыг ажлын байраар ханган, хөдөлмөрийн харилцаанд оруулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр бодитой, үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлэх нь ахмадуудын амьжиргаанд төдийгүй эдийн засагт эергээр нөлөөлөх ач холбогдолтой юм.

¹“Хүн амын 2015-2045 оны шинэчилсэн хэтийн тооцоо”, ҮСХ, 2017 он

Хүснэгт 1. Нас баралт, насны бүлэг, хүйсээр, 2005-2016

Насны бүлэг	2005			2010			2011			2012			2013			2014			2015			2016		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	16,480	10,006	6,474	18,293	10,781	7,512	19,159	11,709	7,450	17,761	10,942	6,819	17,247	10,279	6,968	16,521	9,953	6,568	17,620	10,538	7,082	17,763	10,662	7,101
0	938	530	408	1,275	721	554	1,152	634	518	1,143	651	492	1,166	658	508	1,251	723	528	1,234	723	511	1,315	748	567
1-4	304	170	134	446	233	213	614	353	261	463	256	207	389	223	166	307	155	152	316	168	148	301	173	128
5-9	93	48	45	124	74	50	196	98	98	147	93	54	114	68	46	119	76	43	126	79	47	119	77	42
10-14	136	88	48	122	71	51	195	137	58	134	87	47	102	65	37	124	80	44	108	73	35	116	69	47
15-19	249	174	75	219	152	67	319	219	100	248	169	79	165	107	58	204	128	76	222	157	65	205	137	68
20-24	363	255	108	424	294	130	537	380	157	451	347	104	333	235	98	318	224	94	322	242	80	293	223	70
25-29	511	365	146	493	335	158	566	404	162	493	372	121	449	330	119	444	332	112	429	304	125	436	309	127
30-34	663	496	167	703	505	198	667	494	173	681	503	178	576	430	146	518	402	116	519	411	108	519	389	130
35-39	800	595	205	843	635	208	945	707	238	849	628	221	756	546	210	739	537	202	717	535	182	699	514	185
40-44	1,116	804	312	1,073	740	333	1,174	850	324	1,075	799	276	987	699	288	968	693	275	961	706	255	939	670	269
45-49	1,269	894	375	1,455	997	458	1,513	1,095	418	1,545	1,123	422	1,284	866	418	1,276	925	351	1,258	888	370	1,233	898	335
50-54	1,130	757	373	1,623	1,089	534	1,803	1,231	572	1,665	1,195	470	1,623	1,096	527	1,584	1,067	517	1,542	1,048	494	1,613	1,122	491
55-59	1,198	723	475	1,364	865	499	1,514	1,032	482	1,458	1,009	449	1,554	1,058	496	1,570	1,057	513	1,801	1,188	613	1,842	1,273	569
60-64	1,402	891	511	1,361	840	521	1,365	860	505	1,284	785	499	1,368	833	535	1,408	894	514	1,454	886	568	1,430	904	526
65-69	1,590	938	652	1,437	827	610	1,392	804	588	1,267	728	539	1,233	716	517	1,203	698	505	1,294	740	554	1,450	809	641
70+	4,718	2,278	2,440	5,331	2,403	2,928	5,207	2,411	2,796	4,858	2,197	2,661	5,148	2,349	2,799	4,488	1,962	2,526	5,317	2,390	2,927	5,253	2,347	2,906

Хүснэгт 2. Тодорхой насыг насалсан хүний цаашид амьдрах дундаж хугацаа /жилээр/, насны бүлгээрх нас баралтын түвшин /1000 хүнд ногдохоор/, хүйсээр, 2006, 2016 он

Нас, насны бүлэг	2006				2016			
	Амьдрах хугацаа, 2006 он		Нас баралтын түвшин, 2006 он		Амьдрах хугацаа, 2016 он		Нас баралтын түвшин, 2016 он	
	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй
0	62.6	69.4	24.6	21.8	65.6	75.1	21.2	17.0
1-4	64.5	70.9	1.7	1.3	65.9	75.2	1.1	0.8
5-9	61.2	67.6	0.4	0.3	62.3	71.7	0.5	0.3
10-14	56.4	62.7	0.5	0.3	57.5	66.8	0.6	0.4
15-19	51.5	57.8	0.9	0.5	52.7	61.9	1.2	0.6
20-24	46.8	53.0	2.0	0.9	47.9	57.1	1.8	0.6
25-29	42.2	48.2	3.4	1.2	43.4	52.3	2.0	0.8
30-34	37.8	43.6	4.7	1.4	38.9	47.5	2.9	1.0
35-39	33.6	39.0	6.9	2.3	34.6	42.8	4.5	1.6
40-44	29.5	34.5	10.4	4.1	30.5	38.2	6.6	2.5
45-49	25.7	30.1	13.3	5.7	26.6	33.7	10.5	3.6
50-54	22.2	26.0	20.2	8.4	23.1	29.4	15.3	5.8
55-59	18.9	22.1	24.8	12.1	19.9	25.4	23.8	8.7
60-64	15.9	18.5	32.6	18.5	17.1	21.6	28.0	12.6
65-69	13.4	15.6	48.6	28.8	14.6	18.1	44.8	24.8
70+	11.7	13.3	90.9	73.8	12.4	15.2	81.1	63.8

Хүснэгт 3. Нийгмийн даатгалын сангийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017*
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая төг	238,566.3	326,576.3	422,640.2	457,009.2	622,718.7	755,496.4	799,217.0	1,018,823.3	1,140,580.6	1,187,436.3	1,314,634.0	2,118,869.1
Үүнээс:												
Тэтгэврийн даатгалын сангийн	174,112.1	241,602.4	314,353.5	330,394.1	462,795.1	532,823.6	491,924.4	635,012.0	704,409.0	718,716.6	767,532.6	1,447,846.6
Тэтгэмжийн даатгалын сангийн	10,533.3	14,623.6	13,017.5	15,171.1	17,996.2	25,115.0	35,450.1	67,283.0	78,408.3	81,098.1	86,874.2	109,019.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн	7,670.0	52,671.3	62,425.2	71,825.8	91,257.5	121,492.2	166,612.8	204,087.2	231,728.0	248,068.4	302,608.8	370,532.9
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	41,084.0	10,434.5	20,296.6	23,876.6	31,556.6	49,062.5	67,942.8	86,676.0	99,740.8	109,748.0	125,136.2	147,595.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн	5,156.9	7,244.5	12,547.4	15,741.6	19,113.3	27,003.1	37,286.9	25,765.1	26,294.5	29,805.2	32,482.4	43,875.3
Нийгмийн даатгалын сангийн орлогын бүтэц, хувийн жингээр												
Үүнээс:	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэтгэврийн даатгалын сангийн	73.0	74.0	74.4	72.3	74.3	70.5	61.6	62.3	61.8	60.5	58.4	68.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	4.4	4.5	3.1	3.3	2.9	3.3	4.4	6.6	6.9	6.8	6.6	5.1
Эрүүл мэндийн даатгалын сангийн	3.2	16.1	14.8	15.7	14.7	16.1	20.8	20.0	20.3	20.9	23.0	17.5
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	17.2	3.2	4.8	5.2	5.1	6.5	8.5	8.5	8.7	9.2	9.5	7.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	2.2	2.2	3.0	3.4	3.1	3.6	4.7	2.5	2.3	2.5	2.5	2.1
Нийгмийн даатгалд даатгуулагчид, мян.хүн	480.9	534.1	599.4	609.0	658.0	757.2	863.2	978.2	1,018.6	989.0	1,028.0	1,040.2
Заавал	448.5	482.8	550.0	557.3	594.3	675.6	761.9	830.2	832.9	799.8	799.5	843.8
Сайн дураар	32.4	51.3	49.4	51.7	63.7	81.6	101.3	148.1	185.7	189.2	228.5	196.5
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая төг	199,517.4	309,766.2	466,808.0	497,478.1	531,417.6	607,106.5	943,399.9	1,054,178.5	1,301,122.3	1,560,370.0	1,786,181.8	1,890,083.5
Үүнээс:												
Олгосон тэтгэврийн хэмжээ, сая төг	158,024.3	290,143.2	341,060.2	345,848.2	375,032.7	458,206.0	734,130.6	837,486.3	1,011,858.0	1,198,946.3	1,330,654.7	1,415,411.3
Өндөр настны	111,790.0	199,905.1	233,603.5	240,251.9	265,643.3	328,724.0	516,542.0	593,268.5	724,779.1	867,747.6	973,767.0	1,066,283.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	20,573.7	47,239.0	57,074.4	56,963.6	59,255.6	70,211.0	111,798.7	124,946.0	156,258.8	184,755.9	200,630.6	182,998.6
Тэжээгчээ алдсаны	15,354.0	27,219.9	30,391.9	28,000.6	27,378.6	30,677.6	47,147.6	50,364.2	54,852.4	59,806.1	63,144.2	60,177.5
Цэргийн	10,306.6	15,779.2	19,990.4	20,632.1	22,755.2	28,593.4	58,642.3	68,907.6	75,967.7	86,636.7	93,112.9	105,951.8
Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая төг	41,493.1	19,623.0	125,747.8	151,629.9	156,384.9	148,900.5	209,269.3	216,692.2	289,264.3	361,423.7	455,527.1	474,672.2
Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувийн жингээр	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Олгосон тэтгэвэр	79.2	93.7	73.1	69.5	70.6	75.5	77.8	79.4	77.8	76.8	74.5	74.9
Өндөр настны тэтгэвэр	56.0	64.5	50.0	48.3	50.0	54.1	54.8	56.3	55.7	55.6	54.5	56.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	10.3	15.2	12.2	11.5	11.2	11.6	11.9	11.9	12.0	11.8	11.2	9.7
Тэжээгчээ алдсаны	7.7	8.8	6.5	5.6	5.2	5.1	5.0	4.8	4.2	3.8	3.5	3.2
Цэргийн	5.2	5.1	4.3	4.1	4.3	4.7	6.2	6.5	5.8	5.6	5.2	5.6
Олгосон тэтгэмжийн хэмжээ, сая төг	20.8	6.3	26.9	30.5	29.4	24.5	22.2	20.6	22.2	23.2	25.5	25.1
Тэтгэвэр авагчдын тоо, мян.хүн	290.5	301.2	300.6	335.8	337.5	332.3	334.6	336.9	345.8	387.3	376.9	388.3
Өндөр насны тэтгэвэрт авагчдын	190.1	193.6	193.3	213.2	218.8	219.6	224.7	230.3	242.5	268.4	269.0	282.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	51.9	59.9	62.0	71.5	70.0	67.0	65.8	64.5	65.4	77.9	70.1	67.9
Тэжээгчээ алдсаны	35.4	36.0	33.3	37.9	35.1	32.1	29.9	27.4	23.3	25.6	22.5	21
Цэргийн	13.1	11.7	12.0	13.2	13.6	13.6	14.2	14.7	14.6	15.4	15.3	17.3
Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын зөрүү	39,048.9	16,810.1	-44,167.8	-40,468.9	91,301.1	148,389.9	-144,182.9	-35,355.2	-160,541.7	-372,933.7	-471,547.8	228,785.6
Тэтгэврийн насны хүн ам**, мян.хүн	196.1	195.2	199.8	201.2	202.7	204.5	214.7	222.9	243.8	244.2	257.5	-